



БАЙГАЛЬ ОРЧИН,  
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН  
ЯАМ



АЗИЙН ХӨГЖЛИЙН  
БАНК



ТОГТВОРТОЙ АЯЛАЛ  
ЖУУЛЧЛАЛЫГ  
ХӨГЖҮҮЛЭХ ТӨСӨЛ

**АЗИЙН ХӨГЖЛИЙН БАНКНЫ САНХҮҮЖИЛТЭЭР БОАЖЯ-С  
ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ ТОГТВОРТОЙ АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫГ  
ХӨГЖҮҮЛЭХ ТӨСӨЛ МОН(3787/3788)АЗ: ХАТГАЛ, ХАНХ,  
ДАДАЛ СУМДЫН ХОГ ХАЯГДЛЫН БАЙГУУЛАМЖЫН БАРИЛГЫН  
АЖИЛ**

---

**ХЭНТИЙ АЙМГИЙН ДАДАЛ СУМЫН НУТАГТ “БИЛГҮҮН-  
ОД КОНСТРАКШН” ХХК-НИЙ ГҮЙЦЭТГЭГЧЭЭР  
АЖИЛЛАЖ БУЙ ДАДАЛ СУМЫН ХОГ ХАЯГДЛЫН  
БАЙГУУЛАМЖ ТӨСЛИЙН БОМТ-НЫ 2023 ОНЫ  
БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

**БАРИЛГЫН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭГЧ:  
“БИЛГҮҮН-ОД КОНСТРАКШН” ХХК  
РЕГИСТР: 5450985**

Улаанбаатар хот

2023 он

АЗИЙН ХӨГЖЛИЙН БАНКНЫ САНХҮҮЖИЛТЭЭР БОАЖЯ-С ХЭРЭГЖҮҮЛЖ  
БУЙ ТОГТВОРТОЙ АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ ТӨСӨЛ  
МОН(3787/3788)АЗ: ХАТГАЛ, ХАНХ, ДАДАЛ СУМДЫН ХОГ ХАЯГДЛЫН  
БАЙГУУЛАМЖЫН БАРИЛГЫН АЖИЛ

ХЭНТИЙ АЙМГИЙН ДАДАЛ СУМЫН НУТАГТ “БИЛГҮҮН-ОД  
КОНСТРАКШН” ХХК-НИЙ ГҮЙЦЭТГЭГЧЭЭР АЖИЛЛАЖ БУЙ  
ДАДАЛ СУМЫН ХОГ ХАЯГДЛЫН БАЙГУУЛАМЖ ТӨСЛИЙН  
БОМТ-НЫ 2023 ОНЫ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

БАРИЛГЫН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭГЧ: “БИЛГҮҮН-ОД КОНСТРАКШН” ХХК  
РЕГИСТР: 5450985

**ХЯНАСАН:**

ХЭНТИЙ АЙМГИЙН БОАЖГ-Н МЭРГЭЖИЛТЭН:

**ХЭРЭГЖИЛТИЙГ ГАРГАСАН:**

“БИЛГҮҮН-ОД КОНСТРАКШН” ХХК-НИЙ ЗАХИРАЛ:

З.ХИШИГБАЯР

“ХЭМЖИЛЗҮЙ” ХХК-НИЙ БОХЭ-Н АЖИЛТАН:

Ч.ДАВААСҮРЭН

**Улаанбаатар хот  
2023 он**

Хэнтий аймгийн Дадал сумын нутагт “Билгүүн-Од констракшн” ХХК-ний гүйцэтгэгчээр ажиллаж буй Дадал сумын  
хог хаягдлын байгууламж төслийн БОМТ-ны 2023 оны биелэлтийн тайлан

## **БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

### **АГУУЛГА**

- ОРШИЛ
- ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА
- БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ  
ЗОРИЛТ
- СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ
- ОРЧНЫ ТОХИЖИЛТ, НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ
- ОСОЛ, ЭРСДЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ
- ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ
- ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ
- НЭГДСЭН ДҮН
- ХАВСРАЛТ

## ОРШИЛ

“Билгүүн-Од констракшн” ХХК нь Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр БОАЖЯ-с хэрэгжүүлж буй Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төслийн Хэнтий аймгийн Дадал сумын нутагт хэрэгжүүлж буй Дадал сумын хог хаягдлын байгууламжын барилгын ажлын гүйцэтгэгчээр ажиллаж байгаа юм. Тус төслийн БОННУ-ний тайланг 2021 онд байгаль орчны үнэлгээний мэргэжлийн “Газар дэлхий” ХХК хийж гүйцэтгэн, БОАЖЯ-аар батлуулсан болно. Ийнхүү батлагдсан БОННУ болон 2023 оны үйл ажиллагааны төлөвлөлт зэргийг үндэслэн төслийн гүйцэтгэгч нь 2023 оны БОМТ-гөө БОАЖЯ-аар батлуулан, төлөвлөгөөний дагуу байгаль хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагааг хэрэгжүүлж ажиллаа.

Байгаль орчны талаархи үйл ажиллагааг цаг үргэлж сайжруулж байхын тулд “Билгүүн-Од констракшн” ХХК дараах үүрэг хүлээж, хэрэгжилтийг ханган ажилладаг. Үүнд:

- Байгаль орчны бохирдлоос сэргийлэх, байгалийн нөөц баялгийг зүй зохистой ашиглах зорилгоор байгаль орчинд учирах нөлөөллийг тодорхойлж, бодитоор үнэлж, бохирдлыг бууруулж, арилгах арга хэмжээ авах;
- Байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомж, бусад холбогдох дүрэм, журмыг сахин биелүүлэх;
- Байгаль орчныг хамгаалах талаар хүлээсэн үүргээ биелүүлэхэд туслах зорилгоор ажилчдад сургалт зохион байгуулах, дэмжлэг үзүүлэх;
- Байгаль орчны төлөвлөгөөг хэрэгжүүлэх, үнэлэх, хянах, хэрэгжилтийг тайлагнах үйл ажиллагааг тогтмол сайжруулах;
- Компанийн удирдлагууд, орон нутгийн иргэд болон хорооны удирдлагатай байгаль орчны асуудлаар нээлттэй, шударга, эргэх холбоо бүхий ажил хэрэгч харилцааг буй болгох;
- “Билгүүн-Од констракшн” ХХК өөрийн үйл ажиллагаа болоод төслийн цар хүрээ, нөхцөл байдал хоорондын бодит уялдаа холбоог хангах үүднээс үйл ажиллагааны тогтолцоонд тодорхой хугацаанд хяналт тавих.

2023 онд БОАЖЯ-аар батлуулсан БОМТ-ний болон бусад нийгмийн хариуцлагын хүрээнд хийгдсэн ажлуудаа энэхүү тайлангаар тайлагнаж байна.



## 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

**Төслийн нэр:** Хэнтий аймгийн Дадал сумын хог хаягдлын төвлөрсөн цэг байгуулах

**Төслийн дугаар:** 2018/Б53

**Төслийн зорилго:** Тухайн төслийн гол зорилго нь Дадал сумын хог хаягдлын менежментийн сайжруулах, хууль, журам, стандартын шаардлагыг хангасан хог хаягдлын төвлөрсөн цэгийн ландфилл байгууламж байгуулах, одоо байгаа хогийн цэгийн талбайг булшилж нөхөн сэргээх зэрэг болно.

**Төслийн ач холбогдол:** Азийн хөгжлийн банкнаас Монгол улсад хэрэгжүүлж буй "Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төсөл (МОН3787/3788)"-ийн "Хэнтий дэд төсөл"-ийн хүрээнд Хэнтий аймгийн Дадал сумын нутаг дэвсгэрт орших одоо байгаа төвлөрсөн хогийн цэгийг дарж булшлах бөгөөд шинээр ландфилл байгууламж бүхий 2 дугаар зэрэглэлийн төвлөрсөн хогийн цэг байгуулна.

**Төсөл хэрэгжүүлэгчийн нэр, хаяг:** "Билгүүн од констракшн" ХХК  
Улсын бүртгэлийн дугаар – 9011270111  
Регистрийн дугаар - 5450985  
Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 1-р хороо,  
Токиогийн гудамж , Палаззо центр 402 тоот  
Утас: 99119850

## 1.1 Төслийн хүчин чадал, товч тодорхойлолт

### *Төслийн хүрээнд хийгдэх бүтээн байгуулалтын ажлууд*

“Дадал сумын хог хаягдлын төвлөрсөн цэг байгуулах төсөл”-ийн хүрээнд шинээр ланфилл байгууламж бүхий хог хаягдлын төвлөрсөн цэг байгуулна. Одоо байгаа хогийн төвлөрсөн цэгийн талбайг бууруулж нөхөн сэргээхээр төлөвлөсөн байна.

Шинээр байгуулах хог хаягдлын төвлөрсөн цэгийг Монгол улсын Хог хаягдлын тухай хуульд заасан ангиллаар “2 дугаар зэрэглэлийн төвлөрсөн цэг” байхаар төлөвлөсөн байна. Тус хог хаягдлын төвлөрсөн цэг нь дараах 5 үндсэн хэсгээс бүрдэнэ. Үүнд:

- Ландфилл;
- Хог хаягдлын талбай;
- Удирдлагын байгууламжууд;
- Зам, талбай;
- Бусад байгууламжууд.

#### 1. Ландфилл байгууламж:

- a. 4-5 м гүн ухсан нүх;
- b. Шороон далан;
- c. Шүүрэл нэвчихээс хамгаалсан доторлогоо, үе давхаргууд;
- d. Шүүрлийг цуглуулах хуримтлуулах систем;
- e. Хог хаягдлын ялзралаас үүсэх хийг зайлуулах хоолой;
- f. Хог хаягдлын хучилтын хөрс нөөцлөх талбайтай;
- g. 2-р ээлжийн ландфилл талбай;
- h. 2-р ээлжийн шороо нөөцлөх талбай.

#### 2. Хог хаягдлын талбай:

- a. Энгийн хог хаягдлыг хүлээн авах, ангилан ялгах талбай;
- b. Аюултай хог хаягдлыг хүлээн авах, ангилан ялгах, хадгалах талбай;
- c. Агуулахын талбай (хог хаягдлын преслэх, дахивар нөөцийг түр хадгалах);
- d. Бордоожуулах талбай (Хүнсний хог хаягдал, малын өтөг бууц).

#### 3. Удирдлагын байгууламжууд:

- a. Деспечрийн хяналт бүртгэлийн байр;
- b. Авто пүү;
- c. Ажилчдын байр (бие засах газар болон хувийн ариун цэвэр сахиулах шүршүүр);
- d. Дугуй ариутгах цэг талбай;
- e. Харуулын байр.

#### 4. Зам, талбай:

- a. Авто зогсоол;
- b. Хүнд машин;
- c. Дотоод зам;
- d. Дадал сумын төв хүрэх гол замаас хог хаягдлын цэг хүртэлх зам (сайжруулсан шороон);

Хэнтий аймгийн Дадал сумын нутагт “Билгүүн-Од констракшн” ХХК-ний гүйцэтгэгчээр ажиллаж буй Дадал сумын хог хаягдлын байгууламж төслийн БОМТ-ны 2023 оны биелэлтийн тайлан

е. Ногоон байгууламжийн талбай;

5. Бусад байгууламжууд:

- а. Цахилгааны дэд станц;
- б. Үерийн хамгаалалтын далан шуудуу, хур борооны ус зайлуулах систем;
- с. Төмөр торон хашаа;
- д. Газрын доорх усны хяналт-шинжилгээний худаг;
- е. Хамгаалалтын бүс (300 м).

Ландфилл байгууламжийн ерөнхий бүтэц зохион байгуулалтын загварыг доорх зургуудаар үзүүлэв.



**Зураг 1. Ландфилл байгууламжийн ерөнхий бүтэц**



Зураг 2. Хогийн давхарлан булах схем

Дадал сумын хог хаягдлын төвлөрсөн цэгийн ландфилл байгууламжийн хүчин чадал нь 31000 м<sup>3</sup> байхаар төлөвлөгдсөн байна (Хүснэгт 1).

Хүснэгт 1. Ландфилл байгууламжийн хүчин чадал

Он, үе шат	Дадал	
	тонн-оор	м <sup>3</sup> -ээр
2021	580	967
2022	502	837
2023	511	851
2024	560	933
2025	536	894
1-р үе шат	2689	4482
2026	666	1.110
2027	803	1.338
2028	952	1.856
2029	1.498	2.140
2030	1.577	2.253
2-р үе шат	5.496	8.427
2031	1.364	1.949
2032	1.384	1.978
2033	1.405	2.007
2034	1.426	2.037
2035	1.348	1.926
3-р үе шат	6.927	9.897
2036	1.369	1.956
2037	1.391	1.987
2038	1.413	2.019
2039	1.436	2.052
Дүн	20.721	30.818
<b>Шинээр тооцсон Ландфиллын хүчин чадал /м<sup>3</sup>/</b>	31,000	
<b>Ажлын даалгавар</b>	20,000	
<b>Зөрүү (+, -)</b>	-14,000	

Хэнтий аймгийн Дадал сумын нутагт “Билгүүн-Од констракшн” ХХК-ний гүйцэтгэгчээр ажиллаж буй Дадал сумын хог хаягдлын байгууламж төслийн БОМТ-ны 2023 оны биелэлтийн тайлан

**Хүснэгт 2. 1 иргэн /жуулчин/-ий 1 өдөрт үүсгэх хог хаягдлын норматив хэмжээ /кг-аар/**

Он	Хатгал тосгон		Ханх сум		Дадал сум	
	Хүн амаас	Жуулчдаас	Хүн амаас	Жуулчдаас	Хүн амаас	Жуулчдаас
2021-2028 он	0.3	0.6	0.3	0.6	0.4	0.4
2029 он	0.5	0.6	0.4	0.6	0.6	0.6
2030-2039 он	0.5	0.6	0.5	0.6	0.6	0.6


**Төсөл хэрэгжих үе шат, үргэлжлэх хугацаа**

“Дадал сумын хог хаягдлын төвлөрсөн цэг байгуулах төсөл”-ийн зураг төслийн ажлыг “Эн Ай Пи Групп” ХХК 2021 онд гүйцэтгэсэн болно.

Хог хаягдлын төвлөрсөн цэгийн бүтээн байгуулалтын барилгын ажил нь 2022 онд эхлэхээр төлөвлөгдсөн байна. Ажил гүйцэтгэх нийт хугацааг 14 сар байхаар тооцоолсон байна.

**Төслийн талбайн байршил**

“Дадал сумын хог хаягдлын төвлөрсөн цэг байгуулах төсөл”-ийн талбай нь Дадал сумын төвөөс урд зүгт шулуунаар 4.6 км зайд байрлаж байна.




**Зураг 3. Төсөл хэрэгжих байршлыг засах захиргааны хуваарийн зурагт үзүүлэв**

Хэнтий аймгийн Дадал сумын нутагт “Билгүүн-Од констракшн” ХХК-ний гүйцэтгэгчээр ажиллаж буй Дадал сумын хог хаягдлын байгууламж төслийн БОМТ-ны 2023 оны биелэлтийн тайлан



Төсөл хэрэгжих талбайн хүрээлэн буй орчны төлөв байдлыг байр зүйн болон сансрын зурагт буулган доор үзүүлэв (Зураг 8-10). Төслийн талбай орчмын газрын гадаргын 2021 оны төлөв байдлын зургийг нисгэгчгүй нисэх төхөөрөмж буюу "дрон"-оор гадаргаас дээш 180 м-ийн өндрийн түвшинд авч "Agisoft Photoscan Professional" программаар боловсруулан үзүүлэв. Мөн талбай орчмын өндрийн тоон загварыг боловсруулж үзүүлэв (Зураг 11).




**Зураг 4. Төслийн талбайн хүрээлэн буй орчны төлөв байдал (Байр зүйн зурагт буулгаснаар, ЭхМ1:100000)**




**Зураг 5. Төслийн талбайн хүрээлэн буй орчны төлөв байдал (Сансрын зураг)**

Хэнтий аймгийн Дадал сумын нутагт "Билгүүн-Од констракшн" ХХК-ний гүйцэтгэгчээр ажиллаж буй Дадал сумын хог хаягдлын байгууламж төслийн БОМТ-ны 2023 оны биелэлтийн тайлан





**Зураг 6. Төслийн талбайн хүрээлэн буй орчны нисгэгчгүй нисэх төхөөрөмжийн зураг (2021-10-04-ний өдрийн байдлаар)**



**Зураг 7. Төслийн талбай орчмын өндрийн тоон загвар**

Хэнтий аймгийн Дадал сумын нутагт “Билгүүн-Од констракшн” ХХК-ний гүйцэтгэгчээр ажиллаж буй Дадал сумын хог хаягдлын байгууламж төслийн БОМТ-ны 2023 оны биелэлтийн тайлан



## 1.2. Төслийн гүйцэтгэлтэй холбоотой мэдээлэл

АХБанкны хөрөнгө оруулалтаар Дадал суманд "Билгүүн од констракшн" ХХК-ий гүйцэтгэж байгаа "2-р зэрэглэлийн төвлөрсөн хогийн цэг буюу хатуу хог хаягдлыг дарж булшлах байгууламж"-ийн ажил нь улсын хэмжээнд Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төслийн хүрээнд сум орон нутагт хийгдэж буюу анхны байгууламж юм. Тус төсөл нь Хөвсгөл аймгийн Хатгал, Ханх сумд Хэнтий аймгийн Дадал гэсэн 3 суманд эхний удаагаа амжилттай хэрэгжиж байгаараа онцлогтой юм.

2023 оны 11-р сарын 9-нд Дадал сумын хатуу хог хаягдлын байгууламжид урьдчилсан комисс ажиллаа. БОАЖЯ-ны ТНБД-ын даргын 2023 оны А/356 дугаар тушаалаар байгуулагдсан урьдчилсан үзлэг хийх, Улсын комисс ажиллуулах бэлтгэл хангах үүрэг бүхий ажлын хэсэг Хэнтий аймгийн Дадал сумын шинэ хатуу хог хаягдлын байгууламжтай газар дээр нь үзэж танилцан шаардлагатай дараах үндсэн үүрэг, зөвлөмжийг гүйцэтгэгч "Билгүүн-Од констракшн" ХХК-нд өгсөн болно. Хатуу хог хаягдлын байгууламжийн барилга угсралтын ажлууд үндсэндээ дууссан тул байгууламжийн эргэн тойронд хуучин хогийн цэгт дахин ил задгай хог хаягдал үүсгүүлэхгүйн тулд шинэ байгууламжид хог хаягдлыг хүлээн авч туршиж эхлэх ажлыг Дадал сумын ЗДТГ, ашиглагч байгууллагатай хамтран ойрын хугацаанд эхлүүлэхээр шийдвэрлэсэн байна.

ЗТХяналтыг: Хэнтийн аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар хариуцан ажилласан болно.



**Зураг 8. Төслийн бүтээн байгуулалт**

Хэнтий аймгийн Дадал сумын нутагт "Билгүүн-Од констракшн" ХХК-ний гүйцэтгэгчээр ажиллаж буй Дадал сумын хог хаягдлын байгууламж төслийн БОМТ-ны 2023 оны биелэлтийн тайлан



## **1. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ**

“Билгүүн-Од констракшн” ХХК-ний гүйцэтгэгчээр ажиллаж буй Дадал сумын хог хаягдлын байгууламж төслийн барилга угсралтын ажлын үеийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн А/618 дугаар тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам” болон 2021 онд батлагдсан Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланд үндэслэн боловсруулан БОАЖЯ-аар батлуулсан болно.

Энэхүү байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилго нь төслийн барилга, газар шорооны ажлын үйл ажиллагаанаас агаарт үүсгэж буй тоосжилт, хөрсний элэгдэл, доройтол, ургамлан нөмрөгийн доройтол, хог хаягдлын нөлөөлөл, хатуу шингэн хог хаягдлаас үүсч болзошгүй сөрөг нөлөөллүүдийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэхэд чиглэгдэнэ.

2023 оны БОМТ-г хэрэгжүүлэхэд 26 720 000 (хорин зургаан сая долоон зуун хорин мянга) төгрөг төлөвлөсөн байна.

## **2. ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

Байгаль орчны менежментийн биелэлтийн тайлан хийхдээ 2021 онд батлагдсан төслийн БОННУ-ний тайлан, 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зорилтуудтай уялдуулан хийж гүйцэтгэлээ. Дээр дурдснаар энэхүү төсөл нь өөрөө байгаль хамгаалах үйл ажиллагааны томоохон хэсэг болж байгаа юм. Өөрөөр хэлбэл хуучин хогийн цэг нь салхиар хог өргөн нутгийг хамран тархаж байсан болно.

Энэхүү байгальд ээлтэй төвлөрсөн хогийн цэгийн байгууламж байгуулагдснаар дээрх болон бусад олон бохирдол, эрсдлүүд байхгүй болж байгаа нь төслийн гол зорилгын биелэлт юм. Ийнхүү бид байгаль ээлтэй байгууламж байгуулж, мөн БОМТ-г хэрэгжүүлж ажилласан болно.

1. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

№	Төслөөс үзүүлэх нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Хэрэгжүүлсэн арга хэмжээ /Гүйцэтгэл/	Баталгаажуулах баримт, фото зураг
---	----------------------------	---	--------------------------------------	-----------------------------------

1. Агаарын бохирдлоос хамгаалах чиглэлээр

1 Төслийн барилгын ажилд ашиглагдах машин механизм, дизель станцаас ялгаран гарах хорт хий орчны агаарыг бохирдуулах

Барилгын ажилд ашиглагдаж буй бүх төрлийн машин механизмд үзлэг оношилгоо засварыг тогтмол хийж, холбогдох стандартын шаардлагад нийцүүлэх


Барилгын ажилд ашиглагдаж буй бүх төрлийн машин механизмд үзлэг оношилгоо засварыг тогтмол хийж ажилласан бөгөөд авто техникийн аюулгүй байдлыг байнга хангаж ажиллаж байна.

Зардлын хэмжээ: 1 050 000 төг




Жич: үлдсэн техникийн үзлэгийн баримт зургийг хавсралтаар оруулав.


№	Төслөөс үзүүлэх нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Хэрэгжүүлсэн арга хэмжээ /Гүйцэтгэл/	Баталгаажуулах баримт, фото зураг
2	Барилгын ажлын талбайгаас болон шороон замаас тоос дэгдэж хүрээлэн буй орчинд тархах	Зам, талбайг услах. Барилгын ажлын үед үүсэх тоосжилтыг дарахын тулд өндөр даралтаар мананжуулан ус шүршигч системийг ашиглах Усны машин ашиглан тоосжилт үүсэх замуудыг дулааны улиралд услах, чийглэх, замыг дагтаршуулах	Агаарын бохирдлоос сэргийлж тоосжилтыг бууруулах үүднээс барилгын ажлын талбайг байнга услаж байсан бөгөөд ялангуяа хуурайшилт ихтэй хаврын улиралд салхи ихтэй өдрийн цагуудад газар шорооны ажлыг түр зогсоох зэргээр агаар бохирдлоос сэргийлж ажилласан болно. Мөн барилгын ажлын явцад 7-р сард хийлгэсэн агаарын шинжилгээний дүн Агаарын чанарын техникийн ерөнхий шаардлага, агаарын чанарын стандарт MNS 4585:2016-г хангаж байгааг гаргасан болно.	
<b>Агаарын бохирдлоос хамгаалах ажлын дүгнэлт</b>			<ol style="list-style-type: none"> <li>1. Автотээврээс үүдэлтэй бохирдол үүсэх нөхцлийг байнга хяналт тавин ажиллаж үзлэгт оруулахаас гадна өдөр тутмын хяналт байнга хийгдэж байсан болно.</li> <li>2. Төслийн бүтээн байгуулалттай холбоотой техник болон үйл ажиллагаанаас хамаарсан тоосжилтыг үүсэхгүй байх тал дээр анхаарч ажилласан болно.</li> </ol>	

№	2. <b>Хөрс орчныг хамгаалах чиглэлээр</b>			
1	<p>Төслийн нөлөөгөөр орчны үржил шимт хөрс, ургамлан бүрхэвч бүхий талбай барилга байгууламж, хүнд даацын машин техникийн үйл ажиллагааны нөлөөнд өртөж, хөрсний элэгдэл, эвдрэл үүсэж ургамлан бүрхэвч сөрөг нөлөөлөлд өртөнө. Барилгын ажлын үед байнгын хөл хөдөлгөөнөөс хөрс, ургамлан бүрхэвч доройтож элэгдэл эвдрэлийн талбай нэмэгдэнэ.</p>	<p>Барилгын ажил явагдах талбай болон материалын тээврийн замыг тэмдэгжүүлэх, олон салаа зам гаргуулахгүй байх. Тус барилгын ажилд ашиглагдах шороон замуудын маршрутыг тогтоож тэмдэгжүүлэх</p>	<p>Барилгын ажлын талбайд замын болон аюулгүй байдлын тэмдэг, тэмдэглэгээг хангалттай хийж өгсөн бөгөөд зөвхөн нэг маршрутын замын дагуу тээвэрлэлт хийж байгаа болно. Жич: зурганд тэмдэгжүүлэлт болон дроноос зурганд замын чиглэлийг харуулав.</p> <p><u>Зардлын хэмжээ: 500 000 төг</u></p>	 <p>The image shows a set of safety signs: a yellow warning sign with an exclamation mark, a red prohibition sign for pedestrians, a green sign with a hard hat icon, a yellow sign with the text 'АНХААР' (Warning) and 'БАРИЛГЫН АЖИЛ ЯВАГДАЖ БАЙНА' (Construction work is in progress), a red sign with the text 'Зөвшөөрөлгүй нэртэрхийг хориглоно' (Prohibit unauthorized entry), and a green sign with the text 'Дуулга малгайтай ажилла' (Work with ear protection). Below the signs is an aerial photograph of a construction site with blue arrows pointing to specific areas. At the bottom right is a smaller photograph of a dirt road with a signpost in a grassy field.</p>

Хэнтий аймгийн Дадал сумын нутагт “Билгүүн-Од констракшн” ХХК-ний гүйцэтгэгчээр ажиллаж буй Дадал сумын хог хаягдлын байгууламж төслийн БОМТ-ны 2023 оны биелэлтийн тайлан


<b>3. Амьтны аймагт үзүүлэх нөлөөллийг багасгах</b>			
<b>1</b>	Төслийн үйл ажиллагаанаас амьтдад үзүүлэх сөрөг нөлөөлөл	Төслийн үйл ажиллагаанд ан амьтад, мал өртөхөөс сэргийлэн ажиллах	Төслийн хүрээнд мал амьтнаас хамгаалсан талбайн хашаа барьж байгуулсан.
			
<b>4. Усан орчинд үзүүлэх нөлөөллийг багасгах</b>			
<b>1</b>	Усыг тооцоогүй ашигласнаас газрын доорх усны нөөц хомсдох	Барилгын ажилд ус авч ашиглах гүний хурднуудтай гэрээ байгуулж, усны төлбөр тооцоог холбогдох журмын дагуу хийх	Зардлын хэмжээ: <b>1 000 000</b> төг
<b>Төлөвлөгөөнд зарцуулсан зардлын хэмжээ:</b>			<b>2 550 000</b> төг

## 2. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

№	Төслөөс үзүүлэх нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Хэрэгжүүлсэн арга хэмжээ /Гүйцэтгэл/	Баталгаажуулах баримт, фото зураг
1	Тэрбум мод тарих үндэсний хөдөлгөөнийг дэмжин ажиллах	Төслийн төлөвлөлттэй холбоотойгоор төслийн гадна талбайд мод тарих	Төслийн талбайд хашааг тойруулан мод тарьж тогтмол усалгаа арчилгаа хийж байна.	

Хэнтий аймгийн Дадал сумын нутагт “Билгүүн-Од констракшн” ХХК-ний гүйцэтгэгчээр ажиллаж буй Дадал сумын хог хаягдлын байгууламж төслийн БОМТ-ны 2023 оны биелэлтийн тайлан



2	Хуучин хогийн цэгийг нөхөн сэргээх	Нөхөн сэргээлт хийх	Хуучин хог хаягдлыг түрж овоолж булах ажлыг хийж гүйцэтгэсэн болно.	
---	---------------------------------------	---------------------	--	---

Хэнтий аймгийн Дадал сумын нутагт “Билгүүн-Од констракшн” ХХК-ний гүйцэтгэгчээр ажиллаж буй Дадал сумын хог хаягдлын байгууламж төслийн БОМТ-ны 2023 оны биелэлтийн тайлан

### 3. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Нөлөөлөлд өртөх түүх, соёлын өв	Хамгаалах арга хэмжээ	Хэрэгжүүлсэн арга хэмжээ	Баталгаажуулах баримт, фото зураг
1	Түүх соёлын өвийн дурсгал	Соёлын өвийн талаарх сургалт, зааварчилгаа өгөх	Хэнтий аймгийн Дадал сум нь эзэн богд Чингис хааны түүхийн өлгий нутаг бөгөөд цаашид түүхэн аялал жуулчлалын томоохон төв болох учраас төслийн ажилчдад түүхийн багш, Ч.Ванчигдашаар сургалт оруулсан болно.	
<b>Төлөвлөгөөнд зарцуулсан зардал:</b>			<b>450 000 төг</b>	



#### 4. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

№	Болзошгүй аюул осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Хэрэгжүүлсэн арга хэмжээ	Баталгаажуулах баримт, фото зураг															
1	Цаг агаарын гэнэтийн үзэгдлээс хог хаягдлын төвлөрсөн цэг барих төслийн үйл ажиллагаа доголдох, зогсох	Цаг агаарын улирлын, сарын, 7 хоногийн, өдөр тутмын урьдчилсан мэдээнүүдийг төслийн үйл ажиллагаанд тогтмол ашиглах	www.tsag-agaar.mn, Хэнтий аймгийн УЦОШГ-н <a href="http://khentii.tsag-agaar.gov.mn/forecast/forecast5days">http://khentii.tsag-agaar.gov.mn/forecast/forecast5days</a> зэрэг сайтуудаас цаг агаарын урьдчилсан сэргийлэх мэдээллүүдийг байнга авч төслийн үйл ажиллагаандаа ашиглан ажиллаж байна. Мөн гар утасны цаг агаарын мэдээлэлтэй холбоотой аппликейшнуудыг ашиглаж байна.	<p>Хэнтий - Дадал сум (Станц: Дадал)</p> <table border="1"> <thead> <tr> <th>НҮМ</th> <th>ДАВАА</th> <th>МЯГМАР</th> <th>ЛХАГВА</th> <th>ПҮРЭВ</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>Шөнө -9°C 3м/с Баягтр уултай</td> <td>Шөнө -14°C 3м/с Баягтр уултай</td> <td>Шөнө -13°C 3м/с Баягтр уултай</td> <td>Шөнө -12°C 3м/с Уулцана</td> <td>Шөнө -11°C 3м/с Баягтр уултай</td> </tr> <tr> <td>Өдөр 4°C 5м/с Баягтр уултай</td> <td>Өдөр 4°C 6м/с Баягтр уултай</td> <td>Өдөр 3°C 3м/с Уулцана</td> <td>Өдөр 1°C 4м/с Уулцана</td> <td>Өдөр 2°C 4м/с Уулцана</td> </tr> </tbody> </table>	НҮМ	ДАВАА	МЯГМАР	ЛХАГВА	ПҮРЭВ	Шөнө -9°C 3м/с Баягтр уултай	Шөнө -14°C 3м/с Баягтр уултай	Шөнө -13°C 3м/с Баягтр уултай	Шөнө -12°C 3м/с Уулцана	Шөнө -11°C 3м/с Баягтр уултай	Өдөр 4°C 5м/с Баягтр уултай	Өдөр 4°C 6м/с Баягтр уултай	Өдөр 3°C 3м/с Уулцана	Өдөр 1°C 4м/с Уулцана	Өдөр 2°C 4м/с Уулцана
НҮМ	ДАВАА	МЯГМАР	ЛХАГВА	ПҮРЭВ															
Шөнө -9°C 3м/с Баягтр уултай	Шөнө -14°C 3м/с Баягтр уултай	Шөнө -13°C 3м/с Баягтр уултай	Шөнө -12°C 3м/с Уулцана	Шөнө -11°C 3м/с Баягтр уултай															
Өдөр 4°C 5м/с Баягтр уултай	Өдөр 4°C 6м/с Баягтр уултай	Өдөр 3°C 3м/с Уулцана	Өдөр 1°C 4м/с Уулцана	Өдөр 2°C 4м/с Уулцана															
2	Гал түймрийн улмаас төслийн үйл Ажиллагаа доголдох, зогсох	Гал түймрээс урьдчилан сэргийлэх сургалт сурталчилгаа, болзошгүй аюулын үед авах арга хэмжээг төслийн нийт ажилтан албан хаагчдад тогтмол хугацаанд танилцуулах	Компаний ажилчдад ШУТИС-н ХШУС-н гамшгаас хамгаалах менежмент хичээлийн багш Ч.Даваасүрэн 2023 оны 8-р сарын 10-нд галын аюулгүй байдал, авах арга хэмжээний талаар сургалтыг зохион байгуулсан болно. Мөн ажилчдад галын аюулгүй байдлыг анхааруулах сурталчилгааны самбарыг байрлуулан ажиллаж байна.  Зардлын хэмжээ: 1 400 000 төг																

Хэнтий аймгийн Дадал сумын нутагт “Билгүүн-Од констракшн” ХХК-ний гүйцэтгэгчээр ажиллаж буй Дадал сумын хог хаягдлын байгууламж төслийн БОМТ-ны 2023 оны биелэлтийн тайлан


№	Болзошгүй аюул осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Хэрэгжүүлсэн арга хэмжээ	Баталгаажуулах баримт, фото зураг
3		Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны дүрэм журмыг сахиулж, хэрэгжилтэд хяналт тавих	Хөдөлмөр аюулгүй байдлын дүрмийг өдөр ажил эхлэхэд танилцуулан, албан ёсоор гарын үсэг зуруулан ХАБ-г журмын дагуу хэрэгжүүлэн ажиллаж байна. Зардлын хэмжээ: 800 000 төг	 
4	Үйлдвэрлэлийн гэнэтийн ослын улмаас хүний эрүүл мэнд, амь насанд сөргөөр нөлөөлөх	Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны сургалтыг тогтмол хугацаанд гүйцэтгэх	Хөдөлмөр хамгааллын сургалтыг энэ асуудлыг давхар хариуцсан инженер нь тогтмол зохион байгуулж, гамшгаас хамгаалах сэргийлэх зөвлөмжийг боловсруулан ажиллаж байна. Зардлын хэмжээ: 500 000 төг	 
5		Ажиллагсдын хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр хангах	Ажилчдад хөдөлмөр хамгааллын хэрэгсэл, хувцсаар байнга хангагдан ажиллаж байна.	

Хэнтий аймгийн Дадал сумын нутагт “Билгүүн-Од констракшн” ХХК-ний гүйцэтгэгчээр ажиллаж буй Дадал сумын хог хаягдлын байгууламж төслийн БОМТ-ны 2023 оны биелэлтийн тайлан

№	Болзошгүй аюул осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Хэрэгжүүлсэн арга хэмжээ	Баталгаажуулах баримт, фото зураг
6		Барилгын ажилчдын түр суурин бүрийг анхны тусламж үзүүлэхэд нэн шаардлагатай хэрэгслүүдээр хангах	<p>Анхны тусламжийг хэрэгслийг болзошгүй бэлэн байдалд бэлтгэн нөөцийг бүрдүүлэн ажиллаж байна. Анхны тусламжийн хэрэгслүүдийг бэлтгэсэн болно.</p> <p>Зардлын хэмжээ: 1 000 000 төг</p>	
7	Ажилчдын хотхоныг зөв зохион байгуулаагүйн улмаас ажилчдын эрүүл мэндэд эрсдэл үүсэх	Бие засах өрөө, бусад ариун цэврийн байгууламжыг сар бүр ариутгаж ажиллах	Зориулалтын стандарт хангасан бие засах газар болон гар угаах цэгийг байгуулан ажилласан бөгөөд сар болгон ариутгал хийсэн.	
<b>Зарцуулсан зардал:</b>			<b>4 620 000 төгрөг</b>	

Хэнтий аймгийн Дадал сумын нутагт “Билгүүн-Од констракшн” ХХК-ний гүйцэтгэгчээр ажиллаж буй Дадал сумын хог хаягдлын байгууламж төслийн БОМТ-ны 2023 оны биелэлтийн тайлан

## 5. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Хэрэгжүүлсэн арга хэмжээ	Баталгаажуулах баримт, фото зураг
1	Ахуйн гаралтай хог хаягдлыг ангилан ялгаж дахин ашиглах, зайлуулах арга хэмжээнүүдийг тодорхойлох	Төслийн талбай	Төслөөс гарч буй хог хаягдлыг ахуйн, аюултай гэсэн 2 хэсэгт хувааж зайлшгүй үүсч байгаа аюултай хог хаягдлыг МУ-н хог хаягдлын хуулийн дагуу аюултай хог хаягдал устгагч байгууллага уруу шилжүүлж байсан болно. Зардлын хэмжээ: 600 000 төг	
2	Үйлдвэрлэлийн гаралтай хаягдлыг ил задгай зориулалтын битүү саванд ангилан ялгаж, хадгалах дахин ашиглах болон үйлдвэрлэгчид нийлүүлэх арга хэмжээнүүдийг тодорхойлох		Төслийн талбай дээр ангилан ялгах хогийг савыг байршуулж хогийг ангилан ялгаж хаяж байсан болно. Зардлын хэмжээ: 1 200 000 төг	
<b>Зарцуулсан зардлын хэмжээ:</b>			<b>1 800 000 төгрөг</b>	

Хэнтий аймгийн Дадал сумын нутагт “Билгүүн-Од констракшн” ХХК-ний гүйцэтгэгчээр ажиллаж буй Дадал сумын хог хаягдлын байгууламж төслийн БОМТ-ны 2023 оны биелэлтийн тайлан

### Хог хаягдлын менежментийн үндсэн зарчим

Тус компанийн хог хаягдлын менежментийн үндсэн зарчим нь дараах байдлаар тодорхойлогдоно.



### Зураг.3. Хог хаягдлын менежментийн үндсэн зарчим

хог хаягдлын менежментийг хэрэгжүүлэх зорилгоор дараах дотоод журмуудыг даган мөрддөг.


1. Хог хаягдлыг цуглуулах, хадгалах, тээвэрлэх, устгах журам
2. Аюултай хог хаягдлыг цуглуулах, хадгалах журам

### Хог хаягдлыг зайлуулах, устгах арга зам

#### Хог хаягдлын ангилан ялгалт

Хог хаягдлын менежментийг үр ашигтай явуулахад хог хаягдлын ангилан ялгалт нэн чухал бөгөөд хаягдлыг зайлуулах тохиромжтой зөв арга замыг тогтоож өгдөг. Ангилан ялгалтыг хог хаягдлыг эх үүсвэр дээр ба хог хаягдлыг хүлээн авах нэгдсэн цэг дээр явуулдаг. Эх үүсвэр дээрх хог хаягдлын ангилан ялгалтыг хялбар, үр дүнтэй байлгах зорилгоор өнгөөр кодчилсон ба хог хаягдлын төрлөөр хаягжуулсан савнуудыг шаардлагатай цэгүүд дээр байрлуулж ашигладаг (Зураг.20).

Хэнтий аймгийн Дадал сумын нутагт “Билгүүн-Од констракшн” ХХК-ний гүйцэтгэгчээр ажиллаж буй Дадал сумын хог хаягдлын байгууламж төслийн БОМТ-ны 2023 оны биелэлтийн тайлан



**Зураг.4. Ажилчдын хотхоноос гарах хаягдлын ангилалт**

Хэнтий аймгийн Дадал сумын нутагт “Билгүүн-Од констракшн” ХХК-ний гүйцэтгэгчээр ажиллаж буй Дадал сумын хог хаягдлын байгууламж төслийн БОМТ-ны 2023 оны биелэлтийн тайлан



## 6. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР


Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Байршил	Гүйцэтэсэн ажил	Баталгаажуулах баримт, фото зураг
<b>Агаар орчны хэмжилт шинжилгээ</b>	Төслийн талбайд 4 байршилд	Хөрсний дээжлэлтийг БОННУ-ний тайлан болон 2023 оны БОМТ-д тусгасны дагуу нийт 4 цэгүүдээс авч, магадлан итгэмжлэгдсэн "Инженер Геодези" ХХК -ний төв лабораторид шинжилгээнд өгч үр дүнг авсан болно. /Хавсралтаар шинжилгээний дүнг хавсаргав./	
<b>Хөрсний орчны хэмжилт шинжилгээ</b>	Төслийн талбайд 4 байршилд	Глобал Энвайрон компанийн мэргэжилтнүүд газар дээр очиж байдалтай танилцан агаарт дахь тоосжилт, дуу чимээний түвшинг зөөврийн багажуудын тусламжтайгаар хийж гүйцэтгэлээ. Дээрх хэмжилт судалгаанд агаарын тоосжилт хэмжигч Particle counter болон Dust track багажуудыг ашигласан болно. Мөн агаарын бусад хийн хэмжилт судалгаа Хэнтий аймгийн УЦУОШГ-н БОШЛ-н техникч Эрдэнэцэцэг хийж гүйцэтгэсэн болно.	 
<b>Ургамлын бичиглэл мониторинг</b>	Төслийн талбайд 4 байршилд	Ургамлын бичиглэлийг торын аргаар хийж гүйцэтгэсэн болно. Тухайн арга нь 1 м x 1 м	

Хэнтий аймгийн Дадал сумын нутагт "Билгүүн-Од констракшн" ХХК-ний гүйцэтгэгчээр ажиллаж буй Дадал сумын хог хаягдлын байгууламж төслийн БОМТ-ны 2023 оны биелэлтийн тайлан

Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Байршил	Гүйцэтэсэн ажил	Баталгаажуулах баримт, фото зураг
<p><b>Бусад шинжилгээ</b></p> <p><b>хэмжилт</b></p>	<p>Төслийн талбайд 4 байршилд</p>	<p>хэмжээтэй квадрат тор дотор байгаа ургамлын бүрхэвчийн байдал, ургамлын өндөр, тоо зэргийн бичиглэлийг хийнэ.</p> <p>Мөн хээрийн судалгааны явцад төслийн талбайгаас цацрагийн тунгийн чадлыг дозиметрээр тодорхойлох ажлыг хийж гүйцэтгэлээ.</p>	
<p><b>Зарцуулсан зардлын хэмжээ:</b></p>		<p><b>6 700 000 төгрөг</b></p>	<p>Хавсралтаар дээж авах цэгүүдийн зургийг оруулав.</p>

Жич: Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг мэргэжлийн байгууллага болон мэргэжилтнүүдтэй гэрээ байгуулан хэрэгжүүлүүлсэн болно.

### 7. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Хэрэгжүүлсэн арга хэмжээ	Баталгаажуулах баримт, фото зураг
1	<p>Дадал сум, Баян-Овоо багийн захиргаатай хамтран төсөлд ажиллах хүсэлтэй иргэдийг бүртгэх, тэднээс ажлын шаардлага хангасан иргэдийг ажлын байраар хангах</p>	<p>Дадал сумын иргэд</p>	<p>Тухайн сумын болон тосгоны иргэдээс туслах ажилтнаар 2-3 хүнийг авч ажиллуулж байна. /Жич: ажиллаж буй иргэдийн иргэний үнэмлэхийг хавсаргав./</p>	

Хэнтий аймгийн Дадал сумын нутагт “Билгүүн-Од констракшн” ХХК-ний гүйцэтгэгчээр ажиллаж буй Дадал сумын хог хаягдлын байгууламж төслийн БОМТ-ны 2023 оны биелэлтийн тайлан



2	Сум, баг, тосгоны удирдлага, ИТХ-тай хамтран ажиллах	Төслийн явцыг орон нутгийн удирдлагуудад танилцуулах	<p>Хэнтий аймгийн Дадал сумын хог хаягдлын менежментийн шинэ төлөвлөлтийн талаарх судалгаа, шийдлийн талаарх танилцуулга уулзалт, мэдээлэл өгөх сургалт яг одоо Дадал сумын иргэний танхимд 2023-6-19-нд хийсэн болно.</p> <p>Хэлэлцүүлэгт Дадал сумын ЗТДГ, ОББЦГ-ын хамгаалалтын захиргаа, Хэнтий аймгийн БОАЖГ, Дадал сумын иргэн, ААНийн төлөөлөл оролцсон болно. Сургалт, хэлэлцүүлгийг: Эн эй ди групп ХХК, зөвлөх Б.Дэлгэрбаяр нар удирдан явуулав.</p> <p>Ерөнхий сайдын ажлын албаны зөвлөх Ш.Шижир-Эрдэнэ болон төслийн нэгжийн баг Хэнтий аймагт ажиллах үеэр аймгийн Засаг дарга Ц.Чогсомжав болон Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн даргатай уулзалт хийлээ.</p> <p>Тус уулзалтаар “Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төсөл”-ийн хэрэгжилтийн талаар мэдээлэл өгч, энэ онд багтаан хамтарч хэрэгжүүлэх ажлуудын талаар санал солилцлоо.</p> <p>Зардлын хэмжээ: 1 500 000 төг</p>	
3	“Байгаль орчны менежментийн төлөвлөгөө”-г боловсруулж, эрх бүхий байгууллагаар батлуулахад бэлэн болгох	Төслийн талбайд хамрах	<p>Төслийн БОМТ-ны төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх асуудал дээр зөвлөгөө авах зорилгоор мэргэжлийн Глобал Энвайрон ХХК-тай гэрээ байгуулан зөвлөхөөр ажиллуулж байна.</p> <p>Зардлын хэмжээ: 5 600 000 төг</p>	Хавсралтаар гэрээний баталгаажуулсан хэсгийг оруулав.
<b>Зарцуулсан зардлын хэмжээ:</b>		<b>7 100 000 төгрөг</b>		

Хэнтий аймгийн Дадал сумын нутагт “Билгүүн-Од констракшн” ХХК-ний гүйцэтгэгчээр ажиллаж буй Дадал сумын хог хаягдлын байгууламж төслийн БОМТ-ны 2023 оны биелэлтийн тайлан

**7. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСЭД ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Төслөөс үзүүлэх нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Хэрэгжүүлсэн арга хэмжээ /Гүйцэтгэл/	Баталгаажуулах баримт, фото зураг										
1	2023 оны БОМТ-ний биелэлтийн үр дүнгийн тайланг Хөвсгөл аймгийн байгаль орчны газарт хүргүүлнэ.	БОМТ-ний биелэлтийн үр дүнг тодорхой тусгаж, фото зургаар баримтжуулсан байх	БОМТ-ний биелэлтийн үр дүнг тухай бүр нь Азийн хөгжлийн банкны Тогтвортой аялал жуулчлал төсөлд нэгжид байнга тайлагнаж явсан болно. Мөн биелэлтийн цахим хэлбэрээр илгээсэн болно.	<p>“БИЛГҮҮН ОД КОНСТРАКШН” ХХК</p> <p>ХЭНТИЙ АЙМГИЙН ХАТГАЛ СУМЫН ХОГ ХАЯГДЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСЭД ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ</p> <p>БОМТ-НИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН</p> <p>2023 ОНЫ БОМТ-НЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН</p> <p>Гэрээ гүйцэтгэгчийн нэр: “Билгүүн Од констракшн” ХХК Байгаль орчны аялалын өвөг үр, утас, мэдээ хаяг: Ч.Дадалсүрэн, утас: 99998317, хаяг хаяг: <a href="mailto:danva12@gmail.com">danva12@gmail.com</a></p> <p>1. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ КИТЭЭЛТ</p> <table border="1"> <thead> <tr> <th>№</th> <th>Тасварт үзүүлэх үзүүлэлтүүд</th> <th>Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ</th> <th>Хэрэгжүүлсэн арга хэмжээ</th> <th>Баталгаажуулах баримт, фото зураг</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>1.</td> <td>Аялалын богиносгоо хангах зорилго</td> <td>Баруунд аялалын богиносгоо бүр бүр тархих зангаа хангахад үзэл санаагаа зохицох, тусламж авах, аялалын богино, арга төрөлхийг жуураг болгож байгаа хэргийг мэдэх, хуульчлан хэрэгжих зорилго</td> <td>Баруунд аялалын богиносгоо бүр бүр тархих зангаа хангахад үзэл санаагаа зохицох, тусламж авах, аялалын богино, арга төрөлхийг жуураг болгож байгаа хэргийг мэдэх, хуульчлан хэрэгжих зорилго</td> <td></td> </tr> </tbody> </table> <p>Гүйцэтгэгч: “БИЛГҮҮН ОД КОНСТРАКШН” ХХК</p>	№	Тасварт үзүүлэх үзүүлэлтүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Хэрэгжүүлсэн арга хэмжээ	Баталгаажуулах баримт, фото зураг	1.	Аялалын богиносгоо хангах зорилго	Баруунд аялалын богиносгоо бүр бүр тархих зангаа хангахад үзэл санаагаа зохицох, тусламж авах, аялалын богино, арга төрөлхийг жуураг болгож байгаа хэргийг мэдэх, хуульчлан хэрэгжих зорилго	Баруунд аялалын богиносгоо бүр бүр тархих зангаа хангахад үзэл санаагаа зохицох, тусламж авах, аялалын богино, арга төрөлхийг жуураг болгож байгаа хэргийг мэдэх, хуульчлан хэрэгжих зорилго	
№	Тасварт үзүүлэх үзүүлэлтүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Хэрэгжүүлсэн арга хэмжээ	Баталгаажуулах баримт, фото зураг										
1.	Аялалын богиносгоо хангах зорилго	Баруунд аялалын богиносгоо бүр бүр тархих зангаа хангахад үзэл санаагаа зохицох, тусламж авах, аялалын богино, арга төрөлхийг жуураг болгож байгаа хэргийг мэдэх, хуульчлан хэрэгжих зорилго	Баруунд аялалын богиносгоо бүр бүр тархих зангаа хангахад үзэл санаагаа зохицох, тусламж авах, аялалын богино, арга төрөлхийг жуураг болгож байгаа хэргийг мэдэх, хуульчлан хэрэгжих зорилго											

Хэнтий аймгийн Дадал сумын нутагт “Билгүүн-Од констракшн” ХХК-ний гүйцэтгэгчээр ажиллаж буй Дадал сумын хог хаягдлын байгууламж төслийн БОМТ-ны 2023 оны биелэлтийн тайлан

2	2023 оны БОМТ-ний биелэлтийн үр дүнгийн тайланг сумын Иргэдийн төлөөлөгчдийн хуралд танилцуулах		2023 оны БОМТ-гоо сумын байцаагчдаа танилцуулан дүгнүүлж авсан болно. БОМТ-ны биелэлтийн тайлангаа <a href="http://www.eic.mn">www.eic.mn</a> , болон <a href="mailto:khentiinature@gmail.com">khentiinature@gmail.com</a> хаягуудаар цахим хэлбэрээр тайлагнасан болно.	
---	---	--	--	--

Хэнтий аймгийн Дадал сумын нутагт “Билгүүн-Од констракшн” ХХК-ний гүйцэтгэгчээр ажиллаж буй Дадал сумын хог хаягдлын байгууламж төслийн БОМТ-ны 2023 оны биелэлтийн тайлан

### 8. 2023 ОНЫ БОМТ-НИЙ БИЕЛЭЛТИЙН НЭГДСЭН ДҮН

Төслийн 2023 оны БОМТ-ны хэрэгжилтийн тайланг БОАЖЯ-аар батлагдсан төлөвлөгөөний хүрээнд бичиж тайлагнасан болно.

МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	ЗАРДЛЫН ХЭМЖЭЭ	ТАЙЛБАР
СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ	2 550,000	
ОРЧНЫ ТОХИЖИЛТ ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	-	
ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	450,000	
ОСОЛ ЭРСДЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	4,620,000	
ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	1 800 000	
ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР	6,700,000	
УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ	7 100 000	
ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСЭД ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ	3 500 000	
<b>2023 ОНЫ БОМТ-НЫ ХЭРЭГЖИЛТЭНД ЗАРЦУУЛСАН ДҮН</b>		<b>26 720 000</b>

Хэнтий аймгийн Дадал сумын нутагт “Билгүүн-Од констракшн” ХХК-ний гүйцэтгэгчээр ажиллаж буй Дадал сумын хог хаягдлын байгууламж төслийн БОМТ-ны 2023 оны биелэлтийн тайлан


## **БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАНГИЙН ХАВСРАЛТ**

1. Шинжилгээний дүн – Хөрсний хүнд элементийн шинжилгээний дүн -2023
2. Шинжилгээний дүн –Агаарын шинжилгээний дүн, 2023
3. Шинжилгээ авсан цэгүүдийн байрлал
4. Болзошгүй эрсдлээс хамгаалах төлөвлөгөө, зөвлөмж
5. Бусад холбогдох зураг, баримтууд

### **Ашигласан материалын жагсаалт**

- БОАЖЯ-ны сайдын 2019-10-29-ны №А-618 тушаал “Иргэн, аж ахуйн нэгж байгууллагын тухайн жилд хэрэгжүүлэх Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”
- Шинжилгээний дүнгүүд

ХАВСРАЛТ -1



**ХӨРС СУДЛАЛЫН ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИ**  
ИНЖЕНЕР ГЕОДЕЗИ ХХК  
Утас/Факс 77278899, 77288899  
E-mail: soil\_lab@geo-mongol.mn  
Дугаар: 23/3076

Дээж авсан огноо: 2023 он 08 сарын 10  
Шинжилгээ хийсэн огноо: 2023 он 08 сарын 11-12  
Дээж авсан газрын нэр: Хэнтий аймаг, Дадал сум, Хог хаягдлын төвлөрсөн цэг байгуулах төсөл  
Координат: 48°59'12.8" 111°37'07.5"  
Дээж шинжлүүлсэн байгууллага, хувь хүн: "Билгүүн Од Канстракшн" ХХК  
Харилцах утас: 99998517, 88830119

Хөрсний химийн задлан шинжилгээний дүн

№	Лаб №	Дээжний нэр	Гүн, см	рН	Давс, %	ЦДЧ, dsm	Ялзмаг, %	CaCO <sub>2</sub> , %	Шингээгдсэн н сууринд мг-эв/100 гр		Шим тэжээлийн элементүүд мг/100 гр	
									Ca	Mg	P <sub>2</sub> O <sub>5</sub>	K <sub>2</sub> O
0	1	2	3	4	5	6	7	8	10	11	12	13
1	22/6179	X-1	0-15	7.33	0.02	0.044	1.53	0.00	9.6	4.1	1.5	22

Хөрсний механик бүрэлдэхүүн


№	Лаб №	Дээжний нэр	Гүн, см	Механик ширхэгүүд %, ширхэгийн хэмжээ, мм						
				1-0.25	0.25-0.05	0.05-0.01	0.01-0.005	0.005-0.001	<0.001	
1	22/6179	X-1	0-15	42.2	42.0	0.9	4.0	8.0	2.9	14.9

Хөрсний хүнд металл

№	Лаб №	Дээжний нэр	Гүн, см	Хүнд металл мг/кг					
				Ni /Никель	Cd /Кадми	Pb /Хар тугалга	Cu /Зэс	Zn /Цайр	Cr /Хром
1	22/6179	X-1	0-15	12.8	ND	9.62	5.85	38.1	ND
Хүлгэх агууламж /MNS 5850:2019/				150.0	3.0	100.0	100.0	300.0	150.0
Хорттой агууламж /MNS 5850:2019/				1000.0	10.0	500.0	500.0	600.0	400.0
Аюултай агууламж /MNS 5850:2019/				1800.0	20.0	1200.0	1000.0	1000.0	1500.0
Элементүүдийн зоншвооргодох дээд хэмжээ стандарт				/MNS 5850:2019/					

\*ND-not detect  
Жич: Энэхүү шинжилгээний зарим нь тухайн үеийн дээжтэй хамаргах ба хуульчлан хэрэглэхийг хориглоно.  
Шинжилгээ хийсэн арга стандарт:  
(MNS 3310:1991, MNS ISO 10390:2001, MNS 6824:2020, MNS ISO 11466:2007)

Лабораторын эрхлэгч: Л.Цагаандархи /MS.c/  
Задлан шинжлэгч: Х.Жаргалмаа



**ХӨРС СУДЛАЛЫН ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИ**  
ИНЖЕНЕР ГЕОДЕЗИ ХХК  
Утас/Факс 77278899, 77288899  
E-mail: soil\_lab@geo-mongol.mn  
Дугаар: 23/3077

Дээж авсан огноо: 2023 он 08 сарын 10  
Шинжилгээ хийсэн огноо: 2023 он 08 сарын 11-12  
Дээж авсан газрын нэр: Хэнтий аймаг, Дадал сум, Хог хаягдлын төвлөрсөн цэг байгуулах төсөл  
Координат: 48°59'09.8" 111°37'03.4"  
Дээж шинжлүүлсэн байгууллага, хувь хүн: "Билгүүн Од Канстракшн" ХХК  
Харилцах утас: 99998517, 88830119

Хөрсний химийн задлан шинжилгээний дүн

№	Лаб №	Дээжний нэр	Гүн, см	рН	Давс, %	ЦДЧ, dsm	Ялзмаг, %	CaCO <sub>2</sub> , %	Шингээгдсэн н сууринд мг-эв/100 гр		Шим тэжээлийн элементүүд мг/100 гр	
									Ca	Mg	P <sub>2</sub> O <sub>5</sub>	K <sub>2</sub> O
0	1	2	3	4	5	6	7	8	10	11	12	13
1	22/6180	X-1	0-15	7.06	0.02	0.047	1.12	0.00	7.3	4.1	1.2	27

Хөрсний механик бүрэлдэхүүн

№	Лаб №	Дээжний нэр	Гүн, см	Механик ширхэгүүд %, ширхэгийн хэмжээ, мм						
				1-0.25	0.25-0.05	0.05-0.01	0.01-0.005	0.005-0.001	<0.001	
1	22/6180	X-1	0-15	51.3	28.9	7.6	3.9	3.3	5.1	12.3

Хөрсний хүнд металл

№	Лаб №	Дээжний нэр	Гүн, см	Хүнд металл мг/кг					
				Ni /Никель	Cd /Кадми	Pb /Хар тугалга	Cu /Зэс	Zn /Цайр	Cr /Хром
1	22/6180	X-1	0-15	8.68	ND	7.76	3.82	38.8	ND
Хүлгэх агууламж /MNS 5850:2019/				150.0	3.0	100.0	100.0	300.0	150.0
Хорттой агууламж /MNS 5850:2019/				1000.0	10.0	500.0	500.0	600.0	400.0
Аюултай агууламж /MNS 5850:2019/				1800.0	20.0	1200.0	1000.0	1000.0	1500.0
Элементүүдийн зоншвооргодох дээд хэмжээ стандарт				/MNS 5850:2019/					

\*ND-not detect  
Жич: Энэхүү шинжилгээний зарим нь тухайн үеийн дээжтэй хамаргах ба хуульчлан хэрэглэхийг хориглоно.  
Шинжилгээ хийсэн арга стандарт:  
(MNS 3310:1991, MNS ISO 10390:2001, MNS 6824:2020, MNS ISO 11466:2007)

Лабораторын эрхлэгч: Л.Цагаандархи /MS.c/  
Задлан шинжлэгч: Х.Жаргалмаа

ХАВСРАЛТ -2



**МНАС**  
Accreditation  
System  
Т.У.НЭ  
MNS 2016:02

**ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР  
БАЙГАЛЬ ОРЧИН, ХЭМЖИЛ ЗҮЙН  
ТӨВ ЛАБОРАТОРИ**

17043, Үйлдвэр 2-4, Чингисийн өргөн чөлөө гудамж,  
Хан-Уул дүүрэг, 20-р хороо, Утас: 11-341818  
E-mail: [bohzi@gmail.com](mailto:bohzi@gmail.com)

**БАЙГАЛЬ**  
Орчин, хэмжил зүйн төв лаборатори

**СОРИЛТЫН ДҮН**

Дугаар он/№	: 2023/A-222
Дэжгийг ирүүлсэн газрын нэр, хаяг, утас	: "Билгүүн Од Констракшн" ХХК
Дэжгийг авсан хүний нэр, албан тушаал	: Б.Ганганбайгаль
Дэжгийн тоо, төрөл	: 4 агаар
Сорьц авсан огноо	: 2023.08.08
Дэжгийн тодорхойлолт	: Хэнтий аймаг, Дадал сум Дадал сумын хог хаягдлын цаг байгуулах талбай
Шинжилгээний аргын стандарт	: MNS 0017-2-5-12:2021, MNS 0017-2-5-11:2021 CA3 A07-2016
Шинжилсэн огноо	: 2023.08.10
Хуудасны тоо	: 1/1
Үр дүн :	

№	Сорьц авсан цаг	Сорьц авсан өдөр	Сорьц авсан цаг	Хүхэрлэг хий мг/м³	Азотын давхар исэл мг/м³	Нийт Тоос TSP/ мг/м³
1	Агаар-1 E 111°37'9.3", N 48°59'14.1"	VIII/12	11:40	0.003	0.005	0.032
2	Агаар-2 E 111°37'11.5", N 48°59'8.7"	VIII/12	12:05	0.002	0.007	0.041
3	Агаар-3 E 111°37'3.4", N 48°59'9.8"	VIII/12	11:40	0.001	0.005	0.037
4	Агаар-4 E 111°37'3.2", N 48°59'16.1"	VIII/12	12:05	0.002	0.003	0.028
<b>Агаарын чанарын стандарт MNS 4585:2016 (20 минутын хэмжилт)</b>				<b>0.450</b>	<b>0.200</b>	<b>0.500</b>

Шинжилгээ гүйцэтгэсэн:  
Агаарын хэсгийн инженер

Хянаж баталгаажуулсан:  
Байгаль орчны шинжилгээний хэлтсийн дарга



Д.Түмэндэлгэр


Б.Бархасрагчаа

Хуулбарлан хэрэглэхийг хориглоно.  
Сорилтын дүн нь зөвхөн шинжилсэн сорьцонд хүчинтэй

Хэнтий аймгийн Дадал сумын нутагт "Билгүүн-Од констракшн" ХХК-ний гүйцэтгэгчээр ажиллаж буй Дадал сумын хог хаягдлын байгууламж төслийн БОМТ-ны 2023 оны биелэлтийн тайлан



ХАВСРАЛТ -3



Дээж авсан цэгүүдийн байрлал

Хэнтий аймгийн Дадал сумын нутагт “Билгүүн-Од констракшн” ХХК-ний гүйцэтгэгчээр ажиллаж буй Дадал сумын хог хаягдлын байгууламж төслийн БОМТ-ны 2023 оны биелэлтийн тайлан



ХАВСРАЛТ -4

**1.1. БОЛЗОШГҮЙ ЭРСДЭЛЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ**

**1.1.1. Байгалийн гамшгаас урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ**

Төсөл хэрэгжүүлэх үйл ажиллагааны явцад гарч болзошгүй байгалийн гамшиг, ослоос урьдчилан сэргийлэх зорилгоор дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэх нь зүйтэй.

Үүнд:

**Гал түймрээс сэргийлэх арга хэмжээ**

- Галын аюулгүй ажиллагааг чанд мөрдөн ажиллаж, гал түймэр унтраах хэрэгслэлээр бүрэн хангах, гал түймэр гарсан тохиолдолд гал түймрийг хохирол багатай унтраах арга ажиллагаанд ажиллагсдыг сургаж дадлагажуулсан байх,
- Өндөрлөг газрыг ашиглан аянга зайлуулагч байрлуулах,
- Галын аюулаас урьдчилан сэргийлэх зааварчилгааг бүх ажиллагсдад өгч болзошгүй түймрийн үед ажиллах график төлөвлөгөө гаргаж мөрдөх,
- Гал унтраах багаж хэрэгслэлийн бүрэн бүтэн байдлыг хангаж зохих газруудад байрлуулах,
- Галын аюулаас сэргийлэх дохио, санамж, тэмдгүүдийг шаардлагатай газарт нь байрлуулах,
- Галын аюул гарч болзошгүй хавар намрын улиралд ээлжийн зохион байгуулалтаар эргүүл томилон ажиллуулах,
- Барилга байгууламжийн хийц, бүтээцийн шийдэл нь гал түймэр гарсан тохиолдолд хүн амын аюулгүй байдлыг хангахуйц, гал түймрийг бага хохиролтойгоор унтраах бололцоог хангасан байна. /МУ-н Галын аюулгүй байдлын тухай хууль, 18-р зүйлээс/
- Ойн хээрийн бүрэн сэргийлэн, ялангуяа хуурайшил ихтэй цаг хугацаанд онцгойлон ажиллах



**Зураг.1. Гал унтраах хэрэгслүүд**

***Газар хөдлөлтийн үед өөрийгөө хэрхэн хамгаалах***

**Газар хөдлөлт болохын өмнө:**

- Хэрвээ газар хөдөлбөл ажлын байр, ажилчдын байранд юу юу эвдрэх талаар ярилцах
- Гамшгийн үед ажиллах төлөвлөгөөтэй байх,
- Өрөө, тасалгаандаа хамгийн аюулгүй хэсэг нь хаана байж болохыг урьдчилан тогтооно.
- Аюулгүй газар руу орох /нуугдах/, халхлах, байх зэргээр дадлага, сургуулилт хийх,
- Аюулын үед барилга, байшингаас гарах гарц, аюулын гарцыг мэддэг байх,
- Эмнэлгийн анхны тусламж үзүүлэх чадварыг эзэмших,
- Ус, цахилгааныг хэрхэн яаж унтраах талаар суралцах,
- Өрөө, тасалгааныхаа овор ихтэй, хүнд тавилгыг зохих ёсоор бэхэлж, тогтоох,
- Аюултай болон химийн хортой бодисыг зориулалтын газар тусгаарлан хадгалах,
- Гар чийдэн (нэмэлт зайны хамт), зайгаар ажилладаг жижиг радио, эмийн сан гэх мэт зүйлсийг бэлэн байлгах,
- Нэн шаардлагатай байгууллагын утасны жагсаалтыг мэддэг байх,
- Галын хор ашиглаж сурах гэх зэрэг юм.

Хэнтий аймгийн Дадал сумын нутагт “Билгүүн-Од констракшн” ХХК-ний гүйцэтгэгчээр ажиллаж буй Дадал сумын хог хаягдлын байгууламж төслийн БОМТ-ны 2023 оны биелэлтийн тайлан

### **Газар хөдлөлтийн үед юу хийх вэ?**

#### Газар хөдлөх үед байшин дотор байгаа бол:

- Тайван байх,
- Аюулгүй газар хорогдох(дотор хана, булан, даацын багана гэх мэт),
- Газар хөдлөж эхлэх үед байгаа газрынхаа газарт сууж өөрийгөө халхлах, хүлээх,
- Бат бөх ширээн доогуур орох,
- Цонхноос хол байх,
- Цаг, таазны гэрэл зэрэг дээрээс унах зүйлсийн доор зогсохгүй байх,
- Хаалга онгойлгоод доор нь зогсвол дээрээс унасан зүйл цохих аюул харьцангуй бага байна.

#### Газар хөдлөх үед гадна байгаа бол:

- Байшин, барилга, мод, гэрэл болон цахилгааны шонгоос хол, аюулгүй газар олох,
- Хэрвээ машин дотор байгаа бол чичирхийлэлт зогстол машинаасаа гарах хэрэггүй,
